



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 16-аас
23-ны байдлаар

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 4-р сарын 16-23-ны байдлаар

КОВИД-19 цар тахлын үеийн өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн гаргаж буй гадаад орчны тойм мэдээллийн зургаа дахь дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- Focus Economics агентлагаас “Ковид-19 өвчлөлийн дэлхийн эдийн засагт үзүүлэх нөлөө” түүвэр судалгааг 7 хоног бүр олон улсын шинжээчдийн дунд хийж байна. Энэ оны 4-р сарын 22-нд зарласан түүвэр судалгааны үр дүнгээр **Ковид-19-ийн дэлхийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөө 3-5 нэгж хувь байна гэж шинжээчдийн 41 хувь нь үзсэн бол 28 хувь нь уг нөлөө 5 хувиас өндөр¹ байна гэжээ.** Мөн шинжээчдийн 29 хувь нь дэлхийн эдийн засгийн хямрал 2 улирлын турш үргэлжилнэ гэсэн бол 19 хувь нь 3 улирлын турш үргэлжилнэ гэж хариулжээ. Тэгвэл шинжээчдийн 77 хувь нь төв банкууд мөнгөний тэлэх бодлого хэрэгжүүлнэ. 64 хувь нь дэлхийн эдийн засгийн өсөлтөд үзүүлэх нөлөөг U хэлбэртэй байна гэж үзэв.
- Фитч агентлаг дэлхийн томоохон эдийн засгууд хөл хориогоо сунгаж, эрэлт хурдан сэргэхээргүй байгаа тул дэлхийн эдийн засаг 2020 онд 3.9 хувиар агших төсөөллийг 4-р сарын 22-нд зарлав. Тус байгууллага АНУ-ын эдийн засаг 2020 онд 5.6 хувиар, Евро бүс 7 хувиар, Их Британийн эдийн засаг 6.3 хувиар агшина гэж үзэж байна.
- АНУ-ын эдийн засаг 2020 оны 2-р улиралд 7.9 хувиар агших төсөөллийг 4-р сарын 17-нд Нью-Йоркийн Холбооны Нөөцийн Банкнаас зарлав.** 4-р сарын 22-ны өдөр Сенат цар тахлаас эдийн засгаа хамгаалах 3 дахь ээлжийн багц санхүүжилт болох **484 тэрбум ам.долларын төсвийг баталлаа².** Үүнээс 320 тэрбум ам.долларыг нь жижиг бизнесүүдийг дэмжихэд, үлдсэн хэсгийг Ковид-19 цар тахлын оношилгоог эрчимжүүлэх болон өндөр ачаалалтай байгаа эмнэлгүүдийн үйл ажиллагааг дэмжихэд төсөвлөжээ. Төлөөлөгчдийн танхим уг төслийг баталснаар Ерөнхийлөгч Дональд Трамп дэмжиж, гарын үсэг зурлаа.
- ОХУ-д Ковид-19 цар тахлын тархалт эрчимжиж буй тул **эдийн засгийн хямралтай тэмцэхэд ДНБ-ий 2.8 хувьтай дүйцэхүйц хөрөнгө зарцуулахаа** мэдэгдлээ. Оросын Сангийн сайд хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Үндэсний Баялгийн сангаас 2 их наяд рублийг газрын тосны үнийн уналтаас үүдэлтэй төсвийн алдагдлыг нөхөхөд зарцуулна” гэж мэдэгджээ. Мөн ОХУ-ын Төв банк жижиг, дунд бизнесүүдэд хүүгүй,


¹ Өмнөх 7 хоногийн түүвэр судалгаанаас 19 хувиар нэмэгдсэн.

² FT: [US Congress strikes \\$484bn deal to fund small business](#)

Засгийн газрын батлан даалттай зээл олгохыг дэмжсэн³. Энэ нь ААН-үүд үүдээ барьж ажилгүйдэл газар авахаас сэргийлэх төлөвлөгөөний цөм гэж ОХУ-ын Сангийн сайд хэлэв. Төсвийн бодлогоор эдийн засгийг дэмжих арга хэмжээтэй холбоотойгоор төсвийн алдагдал энэ онд нэг их наяд рубль давж, төсвийн алдагдал болон төсвийн дэмжлэг нийтдээ ДНБ-ий 6.5 хувьтай дүйцэхээр байна. Түүнчлэн, ОХУ шаардлагатай санхүүжилтийг татахаар дотоодын зах зээлд 2.3 их наяд рублийн бонд болон 3.0 тэрбум ам.долларын евро бонд гаргаад байна.

- **Евро бүсийн үйлчилгээний салбарын PMI индекс 3-р сард 50 хувиар буурав.** (Зураг 1). Евро бүсийн үйлчилгээний салбарын PMI индекс 2-р сард 52.6 байсан бол 3-р сард 26.4 болж буурсан нь үйлчилгээний салбар Ковид-19-ийн шоконд хүчтэй өртсөнийг илтгэж байна. Үйлчилгээний салбарын PMI индекс 3-р сард Германд 31.7, Италид 17.4, Испанид 23, Францад 27.4 болж тус тус буурчээ⁴.

Зураг 1. Евро бүсийн орнуудын үйлчилгээний салбарын PMI индекс огцом буурав.



- Европын эдийн засгийн судалгааны “The Zew” институцээс санхүүгийн зах зээлийн шинжээчдийн дунд гаргасан санал асуулгын үр дүнгээр 3-р сард хамгийн хурдтай унаад байсан Евро

³ CBR Preview: [RUB Spike Opens Rate Cut Window](#)

⁴ PMI индекс буюу менежерийн худалдан авагчийн индекс нь 50-с дээш утгатай бол тэлэлт 50-с доош утгатай бол агшилтыг илтгэдэг.

бүсийн эдийн засгийн цаашдын төлөвийн талаарх үнэлгээ хөл хориог сулруулна гэсэн хүлээлтээр сэргэж эхэлсэн ч, 2008 оны хямралаас доогуур түвшинд байна.

- “Google Mobility Report”-оос цар тахлаас үүдэлтэй хөл хорио эхэлснээс хойш **Европын зарим улсуудын жижиглэнгийн худалдаа, хүнсний худалдаа, нийтийн тээвэр, ажлын байр, орон сууцны хэрэглээ хэр хэмжээгээр буурсныг тооцоолжээ.** Ихэнх улсад **жижиглэнгийн худалдаа хамгийн ихээр, дараа нь нийтийн тээвэр, ажлын байр, хүнсний худалдаа буурсан** бол байр, орон сууцны хэрэглээ өссөн байна.
- **Европын орнууд хөл хориог алгуур сулруулж байна**⁵. Итали, Испани, Австрид зарим үйлдвэр, барилгын ажил болон зарим жижиг дэлгүүр, нийтийн цэцэрлэгт хүрээлэн зэргийг нээлээ. Дани улсад өдөр өнжүүлэх болон бага сургуулиуд, Норвегид цэцэрлэг, зарим хувийн эмнэлгүүдийг нээж, сургууль, гоо сайхны үйлчилгээг 4-р сарын 27-оос нээхээр байна. Швейцарт 4-р сарын 27-ноос хөл хориог сулруулахыг мэдэгдлээ. Франц, Швейцарт цэцэрлэг, сургуулиуд 5-р сарын 11-нээс нээгдэхээр байна. Италид 5-р сарын сүүлээс хөл хориог бүрэн цуцлах магадлал өндөр байна.
- **Ковид-19-ийн нөлөөгөөр Азийн эдийн засгуудад аялал жуулчлал, агаарын тээврээс гадна жижиглэнгийн худалдаа эрхэлдэг ЖДҮ-лэгчдэд ирэх санхүүгийн дарамт нэмэгдэж, хөрөнгийн гадагшлах урсгал эрчимтэй явагдаж, ханш нь суларч байна.** Индонезийн рупи болон Тайландын батын ханш Азийн улс орнууд дунд хамгийн ихээр суларчээ.

⁵ FT: [Investors anticipate European economic rebound as lockdown eases](#)

1997-98 оны Азийн санхүүгийн хямралтай харьцуулахад Азийн ихэнх улс орнуудын урсгал данс боломжийн, Төв банкны валютын нөөц хангалттай, санхүүгийн систем нь тогтвортой байгаа хэдий ч, зарим эдийн засгууд шоконд хүчтэй өртөж болзошгүй байна. Тухайлбал, Индонезийн гадаад өр маш өндөр, нөөц бага, дотоод болон үл хөдлөх хөрөнгийн зах зээл нь гадаадын хөрөнгө оруулагчдаас шууд хамааралтай тул эмзэг байдал өндөр гэж үзэж байна. Мөн Малайз улсын эдийн засаг нь түүхий эдийн орлогоос хэт хамааралтай, хувийн хэвшлийн өрийн хэмжээ өндөр болон улс төрийн байдал нь тогтворгүй тул ялгаагүй эрсдэлтэй гэж шинжээчид онцлов.

- **Өмнөд Солонгосын эдийн засаг 1-р улиралд 1.4 хувиар агшсан** нь 2008 оноос хойших эдийн засгийн хамгийн том уналт боллоо. Солонгосын экспортын бараа бүтээгдэхүүний гол том худалдан авагч Хятадын эдийн засаг агшиж, гадаад эрэлт буурсан нь

ийнхүү өсөлтөд нь сөргөөр нөлөөлөхөөр байна.

- **Сингапурын эдийн засаг 1-р улирлын урьдчилсан гүйцэтгэлээр 2.2 хувиар агшив.**
- Японы үйлчилгээний салбарын PMI 4-р сарын урьдчилсан тооцоогоор 22.8 болж түүхэн доод хэмжээнд хүрэхээр байна.
- **Дэлхий нийтийн контейнерийн тээвэр ирэх саруудад 30 хувь хүртэл буурч, гадаад худалдаа агших төлөвтэй** гэж Блүүмберг 4-р сарын 23-нд мэдээлэв. Одоогийн байдлаар контейнерийн тээвэр 15 хувиар буураад байгаа бөгөөд АНУ, Европт эрэлт суларч, агуулахууд дүүрсэн тул нэмж тээвэр хийх орон зай бага гэж олон улсын далайн тээврийн танхимын тэргүүн Esben Poulsen мэдээллээ.

2

ХЯТАДЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- **Хятадын эдийн засаг 4-р сарын 17-ны байдлаар 95 хувийн потенциал түвшнээр ажиллаж байна**⁶. Жилийн 20 сая юанийн орлоготой том аж ахуйн нэгжүүдийн 99 хувь, нийт ажилчдын 94 хувь нь ажилдаа эргэн ороод байна. Амралтын өдрүүдэд олон нийтийн идэвхжил 4-р сарын 4-ний өдрийн байдлаарх 67.8 хувиас 4-р сарын 11-нд 73.8 хувь хүрч нэмэгдээд байгаа нь дотоод эрэлтийг дэмжих боломжийг бүрдүүлнэ гэж Блүүмбергийн шинжээчид дүгнэж байна. Бизнесийн орчны хувьд 4-р сарын 15-ны өдрийн байдлаар жижиг дунд, аж

үйлдвэрлэлийн компаниудын 84 хувь, хувийн аж ахуй нэгжүүдийн 91 хувь, хоол хүнсний хангамжийн бизнесүүдийн /catering/ 87.4 хувь нь үйл ажиллагаагаа сэргээгээд байна⁷.

Ажил эрхлэлтийн хувь болон үйлдвэрүүдийн үйл ажиллагаа хэвийн түвшиндээ хүрээд буй хэдий ч, гадаад эрэлт саарсан, дотоод эрэлт нэмэгдээгүй байгаа тул гадаад худалдаа эрхэлдэг жижиг аж ахуйн нэгжүүдэд хүндрэлтэй хэвээр байна. Нийт нэхмэлийн компаниудын 85 хувь нь үйл ажиллагаагаа хэвийн түвшинд

⁶ Блүүмбергийн шинжээчдийн тооцоолол. Энэ тооцоололд вирусийн голомт Хубэй муж ороогүй болно.

⁷ Хятадын Аж үйлвэр, мэдээлэл технологийн яам болон Үйлдвэр худалдааны холбооны мэдэгдэл.

⁸ Хятадын Үндэсний нэхмэл, хувцасны зөвлөлөөс энэ оны 4-р сарын 8-ний өдөр хийсэн мэдэгдэл.

хадгалахад захиалга нь хангалтгүй байгаа бөгөөд өнгөрсөн 7 хоногт түүвэр судалгаанд оролцсон компаниудын 57 хувь нь захиалгууд цуцлагдсан гэж мэдэгджээ ⁸. Иймд тус салбарт үйлдвэрлэлийн хүчин чадал ашиглалтын хувь доогуур хадгалагдаж, судалгаанд оролцсон нийт компаниудын 9 хувь нь хүчин чадлынхаа 50 хувиас доогуур түвшинд үйл ажиллагаагаа явуулж байна.

- Хятадын эдийн засаг 2020 оны 1-р улиралд 6.8 хувиар агшсан гүйцэтгэлийн дараа Блүүмбергийн шинжээчид төсөөллөө шинэчлэн 2-р улиралд 3.5 хувь, 3-р улиралд 5.3 хувь, 4-улиралд 6.1 хувиар өссөнөөр Хятадын эдийн засаг жилийн дүнгээр **2020 онд 2 хувиар өснө гэж өмнөх (1.4%) төсөөллөө сайжруулжээ.** Төсөөлөл Ковид-19 вируст халдварын нөлөө энэ оны эхний хагаст үргэлжилж, дэлхий дахинаа 3-р улирлаас тогтворжино гэсэн суурь таамаглалд үндэслэжээ. Төсвийн хөрөнгө оруулалт оны эхний 2 сард жилийн 23.1 хувиар агшсан бол 1-р улиралд 12.8 хувиар буурсан үзүүлэлттэй гарав. Үүнд 3-р сард ажилчид ажилдаа алгуур эргэн орсноос гадна төсөв, мөнгөний бодлогын хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ дэмжлэг болов. Хувийн хөрөнгө оруулалт, өрхийн хэрэглээ саарсан хэвээр байгаа бөгөөд жижиглэн худалдаа 15 хувиас илүүгээр агшив.
- Ковид-19-өөс шалтгаалан эрэлт төдийлөн нэмэгдэхээргүй байгаа тул **коксжих нүүрсний дэлхийн зах зээл дээрх үнэ болон Хятадын эрчим хүчний нүүрсний үнэ бага түвшинд хэвээр** байгааг SXCoal 4-р сарын 19-ны 7 хоногийн тоймдоо мэдээлэв. Хятадын голлох 3 муж болох Шаанси, Шанси болон Өвөр Монголын нүүрсний үйлдвэрлэл оны эхний 3 сард 581 сая

тонн хүрч нийт үйлдвэрлэлийн 70 хувийг бүрдүүлж байна. Хятадын голлох 4 боомт дээрх нүүрсний нийт нөөц 4-р сарын 17-ны байдлаар 19.8 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 21.7 хувиар нэмэгдэв. Түүнчлэн нүүрс ашигладаг цахилгаан станцууд дахь нөөц 16.3 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар нэмэгдэж, 29 өдрийн нөөцтэй байна. 2-р улиралд дэд бүтцийн төслүүд эхэлснээр, гангийн эрэлт нэмэгдэж Хятадын жилийн үйлдвэрлэл өмнөх оны түвшинд хүрэх хүлээлттэй байна.


- **Хятадын төсвийн бодлого:** Төсвийн бодлогын хүрээнд тусгай зориулалттай Засгийн газрын бонд гаргалт болон орон нутагт олгох зээлийн хэмжээг нэмэгдүүлэх (local government debt sales) зэрэг арга хэмжээ авснаар ойролцоогоор 2020 онд 4-5 их наяд юанийн төсвийн зарцуулалт хийхээр байна. Төсвийн дэмжлэгийн нөлөөгөөр төсвийн алдагдал 2019 онд ДНБ-ий 5 хувь байсан бол 2020 онд ДНБ-ий 8-9 хувь хүрч нэмэгдэх төлөвтэй.
- **Хятадын мөнгөний бодлого:** Хятадын Ардын Банк (ХАБ) энэ онд бодлогын хүүгээ 0.3-0.4 нэгж хувиар бууруулахаар байгаа бөгөөд 4-р сард бодлогын хүүг 0.2 нэгж хувиар бууруулах хүлээлттэй байна.

3 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРСАН ӨӨРЧЛӨЛТҮҮД

Гадаад худалдаа:


2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн байдлаар гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оны мөн үеэс 1137 сая ам.доллар (31%)-аар буурч, худалдааны тэнцэл 176 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад экспорт 920 сая ам.доллар (44%)-аар, импорт 217 сая ам.доллар (14%)-аар тус тус буурсан байна.

Зураг 2. Гадаад худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зураг 3. Экспорт, импорт, тухайн сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар


Монгол Улс 4 дүгээр сарын эхний 15 хоногт 148.5 сая ам.долларын экспорт, 198.7 сая ам.долларын импорт хийсэн байна. Энэ нь өмнөх сарын сүүлийн 15 хоногтой харьцуулахад экспортын хэмжээ 8.4%-иар өссөн, импортын хэмжээ 18.2%-иар буурсан үзүүлэлт юм.

Экспортын голлох зарим нэр төрлийн бүтээгдэхүүний хувьд өмнөх оны мөн үеэс дараах байдлаар буурсан байна. Үүнд:

- Чулуун нүүрс 5,855 мянган тонн (62.4%);
- Зэсийн баяжмал 61 мянган тонн (14.6%);
- Түүхий нефть 1,498 мянган баррель буюу 80.6%-иар тус тус буурчээ.

Валютын урсгал болон ханш:

Зураг 4. Инфляц, сараар



Эх сурвалж: Монголбанк

Эдийн засаг, бизнесийн идэвхжил саарсан хэдий ч, нийлүүлэлтээс шалтгаалсан инфляц бага зэрэг өслөө. Жилийн инфляц 3 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 6.4%, Улаанбаатар хотын хэмжээнд 6.8% буюу өмнөх 2 дугаар сартай ижил дүнтэй байна. Эдийн засгийн идэвхжил, ерөнхий төлөв саарах хандлагатай байгаа ч иргэд, ААН-үүд нийлүүлэлтийн хомстол үүсэх эрсдэлээс сэргийлж худалдан авалтаа нэмэгдүүлсэн нь инфляц бага зэрэг өсөхөд нөлөөлөв.

Хөрөнгийн зах:

Зураг 5. Хөрөнгийн биржийн Тор-20 индекс




Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Эдийн засгийн идэвхжил саарснаас үүдэн Монголын хөрөнгийн зах зээлд бууралт үргэлжилж байна. 2020 оны 4 дүгээр сарын 23-ны өдөр I, II, III ангиллын 19 хувьцаат компанийн 86,622,296 төгрөгийн үнийн дүн бүхий 328,726 ширхэг хувьцаа арилжаалагдсанаас 7 хувьцаат компанийн хувьцааны ханш өсч, 10 хувьцаат компанийн хувьцааны ханш буурсан бол 2 үнэт цаасны ханш тогтвортой байлаа. Улмаар ТОП-20 индексийн үзүүлэлт 16506.9 болж өнгөрсөн 7 хоногоос 0.7%, оны эхнээс 13.5%-иар буураад байна.

Дэлхийн санхүүгийн зах зээлд Корона вируст халдвараас үүдэлтэй эрсдэл, тодорхойгүй байдал нэмэгдсэнээр голлох хөрөнгийн биржийн индексүүд унаад байсан бол сүүлийн 1 сарын хугацаанд бага зэрэг өслөө. Хөрөнгө оруулагчид эрсдэлтэй багцаа зарж (sell off) илүү хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөнд эх үүсвэрээ байршуулж эхэлснээр **Монгол Улсын Засгийн газар болон компаниудын бондуудын үнэ уналаа.** Хэрэв дэлхийн санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдал даамжирвал Монгол Улсын дахин санхүүжилтийн өртөг нэмэгдэх эрсдэлтэй байна.

Зураг 6. МУ-ын бондуудын өгөөж (%)



Эх сурвалж: Монголбанк

2020 оны 3-р сарын 11-ний өдөр Мөнгөний бодлогын хорооноос санхүүгийн зуучлалыг дэмжих, банкуудын санхүүжилтийн эх үүсвэрийн өртгийг бууруулах, эдийн засгийн идэвхжлийг нэмэгдүүлэх зорилгоор (1) бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулах, (2) төгрөгийн заавал байлгах нөөцийн хувийг 2 нэгж хувиар бууруулж, 324 тэрбум төгрөгийн эх үүсвэр чөлөөлөх, (3) бодлогын хүүний коридорыг бодлогын хүүнээс +/-1 нэгж хувиар шинэчлэн тогтоох багц шийдвэр гаргасан.

Харин 3-р сарын 18-ны өдөр банкны “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам” болон “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д түр хугацааны өөрчлөлт орууллаа. Ингэснээр иргэнд олгосон зээлд тогтоох хугацааны ангиллыг “Хэвийн” зээлийн хувьд 15 хүртэлх хоног байсныг 90 хүртэлх хоног болгож уртасгаж, хэрэглээний болон бизнесийн зээлийн гэрээнд бүтцийн өөрчлөлт хийхэд ангиллыг бууруулахгүй боломжийг бий болголоо.

Түүнчлэн, 3-р сарын 20-ны өдөр банкуудын төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжихэд чиглэсэн арга хэмжээ авч Төв банкнаас арилжааны банкуудад олгох барьцаат зээлийн журамд өөрчлөлт оруулав. Ингэснээр банкууд барьцааны нөхцөл, шаардлагыг хангаснаар Монголбанкнаас 6 сарын хугацаатай (дахин 6 сараар сунгагдах боломжтой) эх үүсвэрийг 11 хувийн хүүтэй авч, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа хангах боломжийг бүрдүүлэв.

4-р сарын 1-ний өдрөөс эхлэн Ковид-19 вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор Монголбанк санаачлан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын хугацаанд арилжааны банк хоорондын бага дүнтэй гүйлгээний шимтгэлийг бууруулах болсноор дийлэнх банканд 20%, зарим банк 100% болгож бууруулахаар боллоо.

Төрөөс хэрэгжүүлж буй орон сууцны ипотекийн хөнгөлөлттэй хүүтэй зээл авсан иргэдийг хамруулах зорилгоор Монголбанк, Сангийн яам, Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК болон банкууд хамтран дараах шийдвэрийг гаргалаа. Үүнд:

- Орон сууцны ипотекийн 8 эсхүл 5 хувийн хүүтэй зээл авсан иргэн зээлийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулах хүсэлт гаргасан тохиолдолд зээлийн үндсэн болон хүүгийн төлбөрийг нэг удаа 3 хүртэлх сараар хойшлуулж, тухайн хугацаагаар зээлийн эргэн төлөлтийн хуваарийг уртасгах;
- Зээлийн эргэн төлөлтөд нь 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрөөс хойш доголдол үүссэн зээлдэгчид энэхүү зохицуулалт үйлчлэх боломжтой бөгөөд доголдол үүссэн хуваарьт өдрөөс эхлэн эргэн төлөлтийг хойшлуулах хугацааг тооцох;
- Зээлдэгч зээлийн эргэн төлөлтөд өөрчлөлт оруулах хүсэлтээ 2020 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө харилцагч банкандаа гаргана.

Эдгээр Монголбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлогын төлөвийг зөөлрүүлэх, банкны зохицуулалтыг түр

хугацаанд зөөлрүүлэх, банкны төлбөрийн чадварыг дэмжихэд чиглэсэн бодлогын багц арга хэмжээ нь санхүүгийн зуучлал хэвийн үргэлжлэх боломжийг бүрдүүлээд зогсохгүй Ковид-19 цар тахлаас үүдэлтэй эдийн засагт учрах сөрөг нөлөөг бууруулахад чухал нөлөөтэй.

УИХ-ын чуулганы 4-р сарын 9-ний өдрийн хуралдаанаар иргэдийн эрүүл мэнд, орлогыг хамгаалах, ажлын байрыг хадгалах, эдийн засгийг идэвхжүүлэх багц арга хэмжээний тухай хууль, тогтоолын төслүүдийг баталлаа.

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4 дүгээр сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлаар эдийн засаг, санхүүгийн зах зээлийн өнөөгийн байдал, ирээдүйн төлөв болон гадаад, дотоод орчны тодорхой бус байдал, эрсдэлийг харгалзан үзэж эдийн засгийн идэвхжлийг дэмжих зорилгоор бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 9 хувьд хүргэхийн зэрэгцээ хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 сар хүртэлх хугацаагаар 1 удаа сунгаж зээлийн сарын эргэн төлөлтийн хэмжээг бууруулах бодлогын багц шийдвэрийг гаргалаа.

Засгийн газрын 4-р сарын 17-ны өдрийн хуралдаанаар, нийгмийн даатгал болон


татварын хөнгөлөлт, чөлөөлөлт, санхүүгийн дэмжлэг олгохтой холбоотой харилцааг зохицуулсан журмыг баталлаа. Уг журамд ажил нь доголдож борлуулалтын орлого нь багассан ч ажлын байраа хадгалж байгаа хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, төрийн болон хувийн хэвшлийн их, дээд сургуулиуд 2020 оны 4 сарын 1-ний өдрөөс 10 сарын 1-ний өдрийг хүртэл хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөхгүй байхаар зохицуулжээ. Түүнчлэн, 2019 оны тайлангаар 1.5 тэрбум төгрөгөөс бага орлоготой ажилласан аж ахуйн нэгжийн 2020 оны 4 сарын 1-нээс 10-р сарын 1 хүртэл олсон үйл ажиллагааны орлогод ногдох албан татварыг чөлөөлөхөөр болсон. Мөн ажил нь зогссон, борлуулалтын орлого нь 50 хувиас дээш хэмжээгээр багассан хувийн аж ахуйн нэгжийн ажилтанд 4 сарын 1-нээс 7 сарын 1 хүртэл сар бүр 200 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгохоор журамд тусгажээ.

Монголбанкнаас гаргасан тушаал, шийдвэр, журмын өөрчлөлтүүдийн хэрэгжилтийг банкуудын иргэдтэй харилцах ажилтнууд ижил түвшинд жигд хангах чиглэлээрх заавар, зөвлөмжийг Монголын банкны холбоотой хамтран 4-р сарын 22-ны өдөр банкуудад хүргүүлжээ.

5 ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Дэлхийн банкны хагас жил тутмын Түүхийн эдийн зах зээлийн төлөв байдал (Commodity Markets Outlook) тайлан өнгөрсөн долоон хоногт гарлаа. Тус тайланд дурдсанаар шинэ коронавирусийн тархалтын нөлөөгөөр ихэнх түүхий эдийн үнэ өнгөрсөн 3 сарын турш огцом буурсан. Тэр дундаа өвчний тархалтыг бууруулах зорилгоор хэрэгжүүлж буй хориг арга хэмжээнүүд нь тээврийн салбарыг ихээхэн хүнд байдалд оруулснаар газрын тосны эрэлт огцом буурч, газрын тосны үнэ их хэмжээгээр сулраад байна. Үүнтэй холбогдуулан 2019 оны 10 сард гаргасан түүхийн эдийн ханшийн таамаглалууддаа ихээхэн өөрчлөлт оруулжээ. Өнөөгийн байдлаар манай улсын экспортын гол эрдэс бүтээгдэхүүнүүдийн үнэ 2020 онд 10-17 хувиар саарах төсөөлөлтэй байна.

Зураг 1. Газрын тосны үнэ




Газрын тосны үнэ. 2020 оны эхэнд АНУ, Ираны зөрчлийн улмаас брент төрлийн газрын тосны ханш 70 орчим ам.долларт хүрсэн. Ковид-19 цар тахал дэлхийн олон оронд тархаж, улс орнууд хилийн хориг, хариу арга хэмжээ авснаар дэлхийн аялал жуулчлал, тээврийн салбарын үйл ажиллагаа хумигдаж, үүнийг дагаад түлш, шатахууны эрэлт буурсан. Нөгөө талд, томоохон газрын тос нийлүүлэгч ОХУ, Саудын Араб зэрэг улсууд үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх шийдвэр

гаргасны улмаас дэлхийн зах зээл дээр газрын тосны илүүдэл үүсэж, 3 дугаар сард газрын тосны үнэ тасралтгүй буурсан. Эдгээр улсууд хэлцэл хийх хүлээлттэй зэрэгцэн газрын тосны үнэ бага зэрэг сэргэж 34.1 ам.долларт хүрсэн хэдий ч, өнгөрсөн 2 долоо хоногийн турш буцаж буурсаар түүхэн доод түвшиндээ хүрлээ.

Түүнчлэн, Хойд Америкийн зах зээлд арилжаалагддаг WTI түүхий газрын тосны 5-р сарын фьючерс үнэ анх удаагаа хасах ам.долларт хүрч унаад байсан нь тогтворжиж, 6-р сарын фьючерс үнийн хаалтын ханш 43 хувийн уналттайгаар 12 ам.доллороос доош тогтов. Цар тахлаас үүдэлтэй аж үйлдвэрлэл болон тээврийн салбарын зогсонги байдал, нефть хадгалах агуулахын багтаамжаас шалтгаалаад үнэ унах дарамттай байв. Газрын тосны үнэ буурч байгаа нь Ковид-19-ийн тархалт өндөртэй байгаа экспортлогч орнуудыг эдийн засгийн хямралд хүргэж болзошгүй байгаа. Нэг баррель газрын тосны дундаж ханш 4 дүгээр сард 28.1 ам.доллар байгаа нь 1 дүгээр сарын дундаж ханшаас 60 хувиар буурсан үзүүлэлт юм. Монгол Улсын гол жишиг болдог 92 октантай шатахууны үнэ Сингапурын биржид 1-р сараас хойш 70 гаруй хувиар буурсан бөгөөд одоо \$18/баррель орчим байна.


Зураг 2. Зэсийн үнэ



Зэсийн үнэ. Манай улсын гол экспортын бүтээгдэхүүнүүдийн нэг болох зэсийн үнэ мөн адил Ковид-19 цар тахлын дэгдэлттэй холбоотойгоор огцом унасан бөгөөд 3 дугаар сарын 23-ны байдлаар 4,609 ам.долларт хүрч буурсан нь сүүлийн 4 жилийн хамгийн доод түвшин юм. Харин БНХАУ-ын үйлдвэрүүдийн үйл ажиллагаа тогтворжиж, тус улсын зэсийн импорт өссөнтэй холбоотойгоор сүүлийн нэг сарын хугацаанд зэсийн үнэ буцаж сэргэн 5,141 ам. долларт хүрлээ. Дэлхийн банкны

түүхий эдийн зах зээлийн талаарх тайланд зэсийн үнэ үргэлжлэн бага түвшинд байх талаар дурдсан бөгөөд 2020 оны төсөөлөл өмнөхөөс 13.5 орчим хувиар бага байхаар таамаглаж байна⁹.

Зураг 3. Алтны хани




Алтны хани. Дэлхийн эдийн засагт аливаа хямрал, тодорхой бус байдал үүсэхтэй зэрэгцэн алтны ханш огцом өсдөг. Үүнтэй холбоотойгоор 2020 оны эхний улиралд 6.9 хувиар өссөн нь 6 улирал дараалан алтны үнэ өссөн үзүүлэлт юм. 3 дугаар сарын эхнээс Хятад улсад тархалт буурч, ихэнх улсуудын засгийн газар, төв банкууд Ковид-19-ийн сөрөг үр нөлөөг бууруулах, эдийн засгаа дэмжих арга хэмжээг шийдэмгий авч байсантай холбоотойгоор

алтны ханш 1,500 орчим ам.долларт хүрч огцом буурсан. Гэвч сүүлийн 3 долоон хоногт АНУ болон зарим улсад вирусийн тархалт эрчимтэй нэмэгдсэнээр алт олборлогч зарим улсад хөл хорио тогтоож, уурхайнуудын үйл ажиллагаа доголдсон зэрэг нь алтны ханшийг өдөөж 1,750 орчим ам.долларт хүргээд байна. Энэ нь 2012 оноос хойших хамгийн дээд түвшин бөгөөд 2019 оны мөн үетэй харьцуулахад 36 хувиар буюу 470 ам.доллараар өссөн үзүүлэлт юм.

⁹ Commodity Markets Outlook, April 2020, World Bank Group

Зураг 4. Төмрийн хүдрийн үнэ



Төмрийн хүдрийн үнэ. 2019 оны 11 сарын эхэнд 80 ам.долларт хүрч байсан төмрийн хүдрийн ханш тасралтгүй өссөөр 2020 оны эхний сард 95 ам.долларт хүрсэн. Дэлхийн нийтэд төмрийн хүдрийн импортын 70%-ийг бүрдүүлдэг Хятад улсад хөл хорио тогтоож, аж үйлдвэрүүд зогсонги байдалд орсон нь төмрийн хүдрийн эрэлт буурахад нөлөөлсөн. Ингэснээр 2 дугаар сарын эхэнд төмрийн хүдрийн үнэ 15.3 хувиар огцом унаж 78.3 ам.долларт хүрчээ. Гэвч,

төмрийн хүдрийн гол нийлүүлэгч Австрали улсад хар шуурга, Бразил улсад их хэмжээний хур тунадас орсонтой холбоотойгоор нийлүүлэлт тасалдан төмрийн хүдрийн үнэ буцаж сэргэхэд нөлөөлөв. Нөгөө талаас Хятад улсын гангийн үйлдвэрүүд хэвийн ажиллаж эхэлсэнтэй холбоотойгоор төмрийн хүдрийн ханш бага зэрэг сэргэх хандлага ажиглагдаж байна. Австрали, Бразил улсын нийлүүлэлт буцаж сэргэх болон дэлхийн гангийн эрэлт 2020 онд буурах хүлээлттэйгээр Дэлхийн банк төмрийн хүдрийн ханшийг 9.4 хувиар буурах төсөөллийг гаргажээ.

Нүүрсний үнэ. Манай улсын гол экспортын бүтээгдэхүүн болох нүүрсний экспорт Ковид-19 цар тахлын улмаас 2 сард түр зогсоод байсан ч, 3-р сараас нээж, Замын-Үүд, Шивээхүрэн, Гашуунсухайт, Ханги зэрэг дөрвөн боомтоор нүүрс тээвэрлэж байна. 2 дугаар сарын эхээр нэг тонн нүүрсний үнэ 830 юань байсан бол 4-р сарын эхэнд 900 орчим юань болж тогтворжсон. Олон улсын зах зээлийн хувьд цахилгаан, дулааны эрэлт харьцангуй тогтвортой байгаагаас шалтгаалан нүүрсний үнэ бусад төрлийн эрчим хүчний түүхий эдтэй харьцуулахад бага хувиар суларсан. Гэхдээ 2020 оны эцэст нүүрсний үнэ 17 хувиар буурна хэмээн Дэлхийн банк таамаглаж байна.